



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/185-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК Захирал: Х.Ариунзул Утас: 99077062 Цахим хаяг: <a href="mailto:ikhnayadaudit@gmail.com">ikhnayadaudit@gmail.com</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b>	<b>4</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>6</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b>	<b>10</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b>	<b>14</b>
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b>	<b>19</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>20</b>

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БЕГ</b>	Боловсролын ерөнхий газар
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>НБББББ</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>МУЕА</b>	Монгол улсын ерөнхий аудитор
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ЗД</b>	Засаг дарга
<b>ХНХС</b>	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР  
СУМЫН ДУЛААНХААН ТОСГОНЫ  
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.ЭНХМАА ТАНАА

2024.09.23 № СЭН-2024/185/НА-СТН-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь

018020215

гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>47,953,717.19</b>	<b>88,266,463.58</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	28,701,311.90	67,637,889.29
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	28,701,311.90	67,637,889.29
31211	Төрийн сангийн харилцах	28,701,311.90	67,637,889.29
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,100,000.00	1,100,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,100,000.00	1,100,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	18,152,405.29	19,528,574.29
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	18,152,405.29	19,528,574.29
35410	Бичиг хэргийн материал	1,161,155.16	2,184,605.16
35420	Аж ахуйн материал	15,537,444.43	15,537,444.43
35460	Хүнсний материал	226,259.70	598,069.70
35470	Бусад хангамжийн материал	1,227,546.00	1,208,455.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,567,323,365.74</b>	<b>1,521,087,164.34</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,567,323,365.74	1,521,087,164.34
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,560,296,315.74	1,514,110,114.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,635,951,632.61	1,635,951,632.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(105,892,490.40)	(139,518,946.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,381,087.34	49,381,087.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,623,376.22)	(32,137,515.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,474,433.21	12,474,433.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,076,936.82)	(11,008,252.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,411,450.00	7,411,450.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,812,214.98)	(9,926,504.94)
39217	Ном	1,482,731.00	1,482,731.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,027,050.00	6,977,049.96
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(249,950.00)	(299,950.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,027,000.00	7,027,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,615,277,082.93</b>	<b>1,609,353,627.92</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>939,900.00</b>	<b>1,117,620.12</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	939,900.00	1,117,620.12
<b>413</b>	<b>Өглөг</b>	939,900.00	1,117,620.12
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	939,900.00	1,117,620.12
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,614,337,182.93</b>	<b>1,608,236,007.80</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,614,337,182.93	1,608,236,007.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	92,623,427.80	92,623,427.80
51101	Өмч: - төрийн	92,623,427.80	92,623,427.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,185,501,318.09	1,179,400,142.96
51210	Өмнөх үеийн үр дүн	1,185,501,318.09	1,185,501,318.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	(6,101,175.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336,212,437.04	336,212,437.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,615,277,082.93</b>	<b>1,609,353,627.92</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлан оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,223,779,546.71</b>	<b>768,209,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,631,851,477.47</b>	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,631,851,477.47	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,613,220,992.18	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	18,630,485.29	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>591,928,069.24</b>	<b>768,209,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	510,055,000.00	692,694,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	510,055,000.00	692,694,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	81,873,069.24	75,515,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,873,069.24	75,515,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>610,542,363.78</b>	<b>774,310,675.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>610,542,363.78</b>	<b>774,310,675.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>610,542,363.78</b>	774,310,675.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	397,960,848.10	513,087,749.59
210101	Үндсэн цалин	297,787,488.10	371,530,711.13
210102	Нэмэгдэл	84,565,759.00	124,219,681.25
210104	Урамшуулал	15,607,601.00	17,337,357.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,163,012.00	64,047,608.02
210201	Тэтгэврийн даатгал	34,364,420.94	44,033,444.52
210202	Тэтгэмжийн даатгал	4,064,678.03	5,225,264.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,191,262.14	4,101,071.35
210204	Ажилгүйдлийн даатгал	768,298.06	920,595.60
210205	Эрүүл мэндийн даатгал	7,774,352.83	9,767,232.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,818,687.24	73,163,020.12
210301	Гэрэл, цахилгаан	5,408,522.52	7,484,420.04
210302	Түлш, халаалт	46,410,164.72	65,378,600.08
210303	Цэвэр, бохир ус	-	300,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	103,500.00	390,000.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	390,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	45,346,740.00	55,161,915.00
210502	Хоол, хүнс	45,346,740.00	55,161,915.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,436,000.00	2,565,110.00
210604	Урсгал засвар	2,436,000.00	2,565,110.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	616,000.00	850,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	616,000.00	850,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	62,097,576.44	65,045,172.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,688,500.00	16,267,621.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,511,450.00	2,541,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,897,626.44	46,236,201.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,613,237,182.93</b>	<b>(6,101,175.13)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,613,237,182.93</b>	<b>(6,101,175.13)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>591,928,069.24</b>	<b>768,209,500.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>591,928,069.24</b>	<b>768,209,500.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	510,055,000.00	692,694,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	510,055,000.00	692,694,100.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	81,873,069.24	75,515,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,873,069.24	75,515,400.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>563,226,757.34</b>	<b>729,272,922.61</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>563,226,757.34</b>	<b>729,272,922.61</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>563,226,757.34</b>	<b>729,272,922.61</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	397,630,855.10	508,123,966.26
210101	Үндсэн цалин	297,528,589.10	356,546,544.06
210102	Нэмэгдэл	84,494,665.00	135,430,737.21
210104	Урамшуулал	15,607,601.00	16,146,684.99
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,493,005.00	68,640,711.35
210201	Тэтгэврийн даатгал	34,683,215.34	47,153,286.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,067,528.43	5,544,030.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,193,521.47	4,378,225.46
210204	Ажилгүйдлийн даатгал	768,788.13	1,050,980.79
210205	Эрүүл мэндийн даатгал	7,779,951.63	10,514,187.87
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,818,687.24	72,045,400.00
210301	Гэрэл, цахилгаан	5,408,522.52	7,484,420.04
210302	Түлш, халаалт	46,410,164.72	64,260,979.96
210303	Цэвэр, бохир ус	-	300,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	44,972,160.00	55,904,405.00
210502	Хоол, хүнс	44,972,160.00	55,904,405.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,496,100.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	1,496,100.00	3,470,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	616,000.00	1,240,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	616,000.00	1,240,100.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16,199,950.00	19,848,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,200,000.00	16,060,540.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,999,950.00	3,787,800.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>28,701,311.90</b>	<b>38,936,577.39</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>28,701,311.90</b>	38,936,577.39
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	28,701,311.90
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	28,701,311.90	67,637,889.29

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	92,623,427.80	336,212,437.04	1,185,501,318.09	1,614,337,182.93
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	92,623,427.80	336,212,437.04	1,185,501,318.09	1,614,337,182.93
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(6,101,175.13)	(6,101,175.13)
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	92,623,427.80	336,212,437.04	1,179,400,142.96	1,608,236,007.80

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	796,910,700.00	729,272,922.61	67,637,777.39	91.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	796,910,700.00	729,272,922.61	67,637,777.39	91.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,910,700.00	729,272,922.61	67,637,777.39	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	564,247,100.00	508,123,966.26	56,123,133.74	90.1
210101	Үндсэн цалин	379,363,300.00	356,546,544.06	22,816,755.94	94.0
210102	Нэмэгдэл	167,531,900.00	135,430,737.21	32,101,162.79	80.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	
210104	Урамшуулал	17,351,900.00	16,146,684.99	1,205,215.01	93.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,414,300.00	68,640,711.35	7,773,588.65	89.8
210201	Тэтгэврийн даатгал	51,961,300.00	47,153,286.69	4,808,013.31	90.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,113,300.00	5,544,030.54	569,269.46	90.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,890,800.00	4,378,225.46	512,574.54	89.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,222,700.00	1,050,980.79	171,719.21	86.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,226,200.00	10,514,187.87	1,712,012.13	86.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,045,400.00	72,045,400.00	-	100.0

210301	Гэрэл, цахилгаан	7,484,420.04	7,484,420.04	-	100.0
210302	Түлш, халаалт	64,260,979.96	64,260,979.96	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00	-	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>59,610,400.00</b>	<b>55,904,405.00</b>	<b>3,705,995.00</b>	93.8
210502	Хоол, хүнс	59,610,400.00	55,904,405.00	3,705,995.00	93.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,470,000.00</b>	<b>3,470,000.00</b>	-	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,262,600.00</b>	<b>1,240,100.00</b>	22,500.00	98.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,262,600.00	1,240,100.00	22,500.00	98.2
210807	Газрын төлбөр			-	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,860,900.00</b>	<b>19,848,340.00</b>	12,560.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,073,100.00	16,060,540.00	12,560.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,787,800.00	3,787,800.00	-	100
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>796,910,700.00</b>	<b>768,209,500.00</b>	<b>28,701,200.00</b>	96.3
	Улсын төсвөөс санхүүжих	692,694,100.00	692,694,100.00	-	100.0
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>75,515,400.00</b>	<b>75,515,400.00</b>	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	75,515,400.00	75,515,400.00	-	100.0
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	<b>28,701,200.00</b>	-	-	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	28,701,200.00	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	28,701,311.90	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	67,637,889.29	-	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь “Суралцагч бүрийн сурлагын хоцрогдлыг арилгая” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Тус байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах нөхцөлийг бүрдүүлж, сурлагын хоцрогдлыг арилгах;

- Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэн, цахим сан болон даалгаврын санг бүрдүүлж ашиглах;
- Багш бүр сургалтын арга хэлбэр, заах арга зүйгээ оновчтой сонгон заах;
- Багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагааг сайжруулах;

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
- *"Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх

итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,609,353.6 мянган төгрөг болж өмнөх оноос 5,923.4 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28,701.3	67,637.9	38,936.6
Авлага	1,100.0	1,100.0	-
Бараа материал	18,152.4	19,528.5	1,376.1
Үндсэн хөрөнгө	1,567,323.3	1,521,087.2	(46,236.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,615,277.0</b>	<b>1,609,353.6</b>	<b>(5,923.4)</b>
Өр төлбөр	939.9	1,117.6	177.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,614,337.1	1,608,236.0	(6,101.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,615,277.0</b>	<b>1,609,353.6</b>	<b>(5,923.4)</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 19,528.5 мянган төгрөг болж 1,376.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 75,441.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 74,064.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,521,087.2 мянган төгрөг болж 46,236.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,117.6 мянган төгрөг болж 177.7 мянган төгрөгөөр өссөн нь халаалтын үнэ тариф шинэчлэн тогтоогдсоноос шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 692,694.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 75,515.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 768,209.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 692,694.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 75,515.4 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 28,701.2 мянган төгрөг нийт 796,910.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 729,272.9 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 56,157.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7,773.6 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 3,706.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,908.9	1,908.9	-	100.0
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	59,610.4	55,904.4	3,706.0	93.9
		3	81816- Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,991.7	2,991.7	-	100.0
		4	81823- Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,893.9	1,893.9	-	100.0
		5	81834- Боловсролын стандарт сургалт	496,619.4	455,001.1	41,618.3	91.6
		6	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	158,371.0	136,057.5	22,313.5	85.9
		7	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	75,515.4	75,514.4	-	100.0
<b>Нийт</b>				<b>796,910.7</b>	<b>729,272.9</b>	<b>67,637.8</b>	<b>91.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь 2023 онд төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнсний материал худалдан авахаар 51,512.0 мянган төгрөг төсөвлөсөн байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг [tender.gov.mn](http://tender.gov.mn) цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад шалгарсан Дөлгөөн болор сан ХХК болон 2 иргэнтэй гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар

цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Их наяд аудит” ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК -д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 610,542.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,105.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас тус байгууллага нь мэдээллийг цаг хугацаанд нь ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

##### **1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал**

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан 55,904.4 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр хүнсний материалыг “Дөлгөөн болор сан” ХХК болон 2 иргэнтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *“Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”*, 48 дугаар зүйлийн 48.5-т *“Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”*, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1. *Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг*, 2. *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан тайлагнах, хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх зөвлөмж хүргүүлэв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Шаамар сумын Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 19,807.2 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрч, 17,269.2 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 2 зөвлөмж хүргүүлсэн байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчлийн хэрэгжилтийг шалгахад алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,415.4 мянган төгрөгийн зөрчил цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, өглөг үүсгэсэн 2 зөрчилд албан шаардлага, санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй 1 зөрчилд зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	2	3,415.4	2	3,415.4	100.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>3,415.4</b>	<b>4</b>	<b>3,415.4</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

2. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,269.2 мянган төгрөгийн 6 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас цахим баримтгүйгээр 137.6 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн.
2. Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд 12,425.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.
3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 818.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэсэн байна.
4. Өр төлбөрийг аккрузал сууриар бүртгээгүйгээс 545.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.
5. Авлага, өр төлбөрийн журналыг харилцагч байгууллага тус бүрээр хөтлөөгүй байна.
6. Цалингийн зардал, НДШ-ийн цалингийн хүснэгт журналаас 3,342.7 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Аудитаар нийт **3,216.3** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,509.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,706.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

## **5.1 Албан шаардлага**

1. Батлагдсан цалингийн зардлаас 2 албан хаагчид “Байгууллагын шилдэг ажилтан”-аар шалгарсан гэх үндэслэлээр шагнал урамшууллын зардалд **1,509.6** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

## **5.2. Зөвлөмж**

### **1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Эд хариуцагчийн тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл, санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын эхний үлдэгдлээс **1,706.7** мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно;*” гэж заасныг зөрчсөн байна.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн зөрчлийг арилгаж, 2024 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

## **2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **2** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”* гэж заасантай нийцэхгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн	1	137.6			1	137.6	1	137.6				
Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан.	1	12,425.2			1	12,425.2	1	12,425.2				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн.	1	818.0			1	818.0	1	818.0				
Акрүэл сууриар бүртгээгүй, өр төлбөрийг дутуу бүртгэсэн.	1	545.7			1	545.7	1	545.7				
Авлага, өр төлбөрийн журналыг харилцагч байгууллага тус бүрээр хөтлөөгүй байна	1				1		1					
Цалингийн зардлыг журналд дутуу тусгасан	1	3,342.7			1	3,342.7	1	3,342.7				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>17,269.2</b>			<b>6</b>	<b>17,269.2</b>	<b>6</b>	<b>17,269.2</b>	<b>6</b>	<b>17,269.2</b>		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Телбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан	1	1,509.6			1	1,509.6				
Санхүүгийн байдлын бараа материалын үлдэгдэл эд хариуцагчийн тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	1,706.7					1	1,706.7		
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг шийдвэрлүүлээгүй	1	-					1	-		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,216.3</b>			<b>1</b>	<b>1,509.6</b>	<b>2</b>	<b>1,706.7</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Телбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй.	1	-				1
Дүн	1	-				1
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>				<b>1</b>